

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН АГААРЫН ЗАМЫН БООМТ
ХАРИУЦСАН ГАЗРААС 2019 ОНЫ АРАВДУГААР САРД ХИЙЖ
ГҮЙЦЭТГЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2019 оны 10 дугаар сарын 28

Улаанбаатар хот

Тус газар нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай, Засгийн газрын 2010 оны 339 дүгээр тогтоолоор баталсан “Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журам”, 2018 оны 145, 146 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын виз олгох журам”, “Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам” болон тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудыг удирдлага болгон иргэнд хөнгөн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэхэд анхаарч 2019 оны 09 дүгээр сарын 26-аас 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдрүүдэд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Нэг. Үндсэн үйл ажиллагааны хүрээнд

1.1. Монгол Улсын виз, бүртгэлийн талаар:

Тайлант хугацаанд нийт 67 орны 514 гадаадын иргэнд зохих ангилал, зориулалтын визийг олгосон бөгөөд үүнээс визийн шилжүүлэг 13, нэг удаагийн орох 440, хоёр удаагийн орох 4, олон удаагийн орох 18, нэг удаагийн гарах-орох 30, хоёр удаагийн гарах-орох 1, олон удаагийн гарах-орох 5, нэг удаагийн дамжин өнгөрөх 3, түр ирэгчийн бүртгэл 91, хасалт 120, оршин суух зөвшөөрлийн хасалт 45 байна.

1.2. Гадаадын иргэдэд тавих хяналт шалгалтын хүрээнд:

Төв аймаг дахь ахлах мэргэжилтэн аймгийн 7 хоног бүрийн шуурхай хуралд сууж, 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Засаг даргын орлогчийн ахалсан бүрэлдэхүүнтэй Алтанбулаг суманд ажиллав.

Тайлангийн хугацаанд төлөвлөгөөт 1 хяналт шалгалтад 5 аж ахуйн нэгж /хамрагдсан гадаадын иргэн 56/ хамрагдсан байна. Тухайлбал, Агаарын замын боомт хариуцсан газрын даргын 2019 оны 10 дугаар сарын 07-ны өдөр баталсан 10/14 дугаар удирдамжийн дагуу мөн сарын 08-аас 10-ны өдрүүдэд 3 хоногийн хугацаатай Төв аймгийн Баянчандмань, Борнуур, Баянцогт, Жаргалант, Лүн, Цээл суманд зам гүүр, үйлдвэрлэлийн барилга байгууламж, уул уурхай, малын гаралтай түүхий эд, махны үйлдвэр, төмрийн үйлдвэрт ажиллаж байгаа гадаадын иргэдийн бичиг баримтанд шалгалт хийсэн. Шалгалтаар Төв аймгийн Баянцогт сумын Гуна 1-р багийн нутагт 3 аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүний эзэмшлийн талбайд хөдөлмөр эрхэлж байгаа 1 орны 3 гадаадын иргэний бичиг баримтыг шалгасан ба зөрчилгүй оршин сууж байна. Баянчандмань сумын 3-р багийн Эрдэнэцагаан даваа гэх нутагт 1 орны 38 гадаадын иргэн нь хөдөлмөр эрхлэх оршин суух зөвшөөрөлтэй байв. Мөн тус сумын Хар үзүүр гэх газар 1 орны 7 гадаадын иргэн хөдөлмөр эрхлэх зөвшөөрөлтэй бичиг баримтын ямар нэгэн зөрчилгүй байлаа. Тус сумын нутаг Бичигт 3 дугаар багт байрлах 1 ААН-ийг шалгахад үйл ажиллагаа явуулаагүй байсан.

Борнуур сумын 1-р багт байрлах 1 ААН-д гадаад ажилчин байхгүй байлаа. Төв аймгийн Жаргалант сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 1 ААН-ийг шалгахад 1 орны хөрөнгө оруулагч 3, хөдөлмөр эрхлэгч 22, нийт 25 гадаадын иргэн байв. Ямар нэгэн зөрчил илрээгүй.

Тайлант хугацаанд Гадаадын иргэдийн оршин суух, хөдөлмөр эрхлэлтэнд дотоод сүлжээ ашиглан мэдээллийн сан бүрдүүлэн Төв аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтэс болон холбогдох байгууллагуудтай мэдээлэл солилцон ажиллаж байна.

Төв аймаг дахь ахлах мэргэжилтэн, хяналтын улсын байцаагч 2019 оны 10 дугаар сарын 07, 14, 21-ний өдрүүдэд аймгийн Засаг даргын дэргэдэх шуурхай хуралд оролцсон. Тус хуралд Төв аймагт үйл ажиллагаа явуулж, оршин сууж байгаа гадаадын иргэдэд хийж байгаа хяналт шалгалтын талаар асуусан асуултанд хариу өгсөн. Төв аймгийн Засаг даргын Тамгын газраас гаргасан удирдамжийн дагуу 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Төв аймгийн Борнуур суманд болсон нээлттэй хаалганы өдөрт оролцож байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүрэг, үйл ажиллагааг сурталчилсан.

“ISM” системээр давхардсан тоогоор 124 орны 26632 гадаадын иргэний мэдээллийг шүүж шалгасан ба орон нутгийн нислэгт шалгалт хийгдээгүй байна.

Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага /IOM/-аас өгсөн бичиг баримтын хуурмаглал шалгах төхөөрөмжийг ашигласан талаарх 2019 оны 3 дугаар улирлын тайланг гарагж 2019 оны 10 дугаар сарын 07-ны өдөр hliang@iom.int цахим хаягаар хүргүүлсэн. Тайлант хугацаанд 27 орны 52 гадаадын иргэний бичиг баримт, мэдээллийг шалгасан бөгөөд зөрчил илрээгүй байна. Харин бичиг баримтын хуурмаглал шалгах төхөөрөмжийг ашиглан тайлант хугацаанд нийт 7 орны 21 гадаадын иргэний бичиг баримт, мэдээллийг шалгасан бөгөөд зөрчил илрээгүй байна.

1.3. Зөрчил шалган шийдвэрлэлтийн талаар:

Тайлангийн хугацаанд бүртгэлийн талаар тогтоосон журам зөрчсөн, визийн хугацаа хэтрүүлсэн, оршин суух зөвшөөрлийн хугацаа хэтрүүлсэн, оршин суух үнэмлэх эзэмших, хадгалах журам зөрчсөн, хуульд заасан хугацаанд оршин суух аваагүй, визийн байх хугацааг хэтрүүлсэн үндэслэлээр 17 орны 60 гадаадын иргэнд 9,450,000 төгрөг, 13 аж ахуйн нэгжид /хамрагдсан гадаадын иргэн 15/ 4,110,000 төгрөг, 0 уригч иргэнийг /урьсан гадаадын иргэн 0/ 0 төгрөг, нийт 13,560,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, зөрчлийг арилган, зөвлөгөө мэдээлэл өгөв.

1.4. Монгол Улсаас албадан гаргасан гадаадын иргэний талаар:

Тайлант хугацаанд албадан гаргах дүгнэлт 3 орны 6 гадаадын иргэнд үйлдэж төвд хүргүүлсэнээр визийн хугацаа хэтрүүлсэн, ирсэн зорилгоосоо өөр үйл ажиллагаа явуулсан үндэслэлээр 2 орны 5 гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргасан байна. Төвөөс 4 орны 4 гадаадын иргэнийг албадан гаргаж буй үйл ажиллагаанд тус газрын албан хаагчид оролцож, тодорхойлолт үйлдэв.

1.5. Хил нэвтрүүлэлгүй буцаасан иргэдийн талаар:

Тайлант хугацаанд Монгол Улсад орох виз, визийн зөвшөөрөлгүй нийт 5 улсын 78 гадаадын иргэнийг Монгол Улсын хилээр оруулаагүй буцаасан байна. Харин гарах визгүй, аж ахуйн нэгжийн албан бичиггүй зэрэг үндэслэлээр нийт 6 орны 15 гадаадын иргэнийг Монгол Улсын хилээр гаргаагүй болно. Шүүх, ШШГЕГ, прокурорын байгууллагын хүсэлтийн дагуу Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэн байхгүй байна.

1.6. Ярилцлагын тэмдэглэл болон баталгаа гаргуулан хил нэвтрүүлсэн талаар:

Монгол Улсад визгүй зорчигч гадаадын иргэн, хөдөлмөр эрхлэх магадлалтай 12 орны 109 гадаадын иргэнтэй ярилцлага хийж, тэмдэглэл хөтлөн хилээр нэвтрүүлсэн. Иргэд харилцан зорчих нөхцлийн талаар байгуулсан Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсад зорчин ирж буй 6 орны 32 гадаадын иргэнийг угтан авч буй уригч 25 иргэнээр баталгааны анкет бөглүүлэн хил нэвтрүүлж, уг гадаадын иргэний гарах хөдөлгөөнд хяналт тавин ажиллаж байна.

1.7. Иргэний харьяаллын талаар:

Хоёрдмол харьяалал үүсгэсэн 4 орны 4 иргэнээр өргөдөл-анкетыг бөглүүлэн холбогдох баримт бичгийг хуулбарлан авч Виз, зөвшөөрөл, харьяатын газарт хүргүүлсэн.

Хоёр. Дотоод ажлын хүрээнд

2.1. Тушаал, төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн талаар:

Тайлант хугацаанд тус газрын дарга нийт 2 тушаал /үндсэн үйл ажиллагаатай холбоотой 1, хүний нөөцтэй холбоотой 1/ батлан гаргаж биелэлтийг тооцон ажилласан ба 2019 оны аравдугаар сард хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 35 ажил хийж гүйцэтгэхээр тусгасан бөгөөд биелэлт 98 хувьтай гарлаа. Түүнчлэн тус газраас 2019 оны арван нэгдүгээр сард хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулсан.

Төвөөс өгсөн үүргийн дагуу дараах мэдээг тогтоосон хугацаанд гаргаж холбогдох нэгжүүдэд хүргүүллээ. Үүнд:

- Тус газрын үндсэн үйл ажиллагааны талаарх хоногийн мэдээг гаргаж өдөр бүр, байгууллагын даргын батлан гаргасан албан даалгаврын биелэлтийг гаргаж 2019 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр, өргөдөл, гомдлын мэдээ, инфографик мэдээг өмнөх оны мөн үетэй харьцуулан гаргаж 10 дугаар сарын 25-ны өдөр, хилийн боомтод ажилласан албан хаагчдын энэ оны 3 дугаар улирлын цагийн бүртгэлийг гаргаж 10 дугаар сарын 08-ны өдөр Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст;

- Тус нэгжийн 2019 оны сүүлийн хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох загварын дагуу боловсруулж 02-ны өдөр, албан хаагчдын ажилласан жил, зэрэг дэв, гадаад улсад дээд боловсрол эзэмшсэн талаарх судалгааг гаргаж 03-ны өдөр, байгууллагын даргын 2019 оны А/345 дугаар “Төрийн үйлчилгээний албан тушаалын ажлын байрны тодорхойлолтыг батлах тухай” тушаалыг албан хаагчдад танилцуулж, уг тодорхойлолттой танилцсан талаар гарын үсэг зуруулж 08-ны өдөр, байгууллагын цахим хуудсанд байршуулах тус газрын даргын талаарх мэдээллийн бэлтгэн 08-ны өдөр, албан хаагчдын ажлыг 2017, 2018 онд үнэлж өгсөн үнэлгээний талаарх судалгааг гаргаж 15-ны өдөр, албан хаагчдын энэ оны 3 дугаар улирлын хил нэвтрэлтийн талаарх судалгааг гаргаж 16-ны өдөр Захиргаа, удирдлагын газарт хүргүүлсэн.

2.2. Архив, албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдлын талаар:

Тус газрын архивын өрөөний чийг, дулааныг өдөр бүр хэмжиж бүртгэл хөтлөн ажиллаж байгаа ба хэмжилтээр дулаан 22-30С, чийг 30-50RH байна. Бичиг хэрэгт 10 албан бичиг ирсэнийг бүртгэлжүүлэн холбогдох албан хаагчид хүлээлгэн өгч, хариутай 7 албан бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавин ажилласан ба 15 албан бичиг боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлэв. Цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд тус газарт ирсэн 10, явсан 15 албан бичиг, тус газрын даргын батлан гаргасан 2 тушаал, тус газрын энэ сарын төлөвлөгөө, түүний биелэлт, тайланг скайнердаж цахим хэлбэрт шилжүүлсэн.

Энэ сард иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан хаагчдаас гаргасан өргөдөл, гомдол байхгүй болно.

2.3. Хүний нөөц, сургалтын талаар:

Байгууллагын даргын 2018 оны Б/347 дугаар тушаалын дагуу тус газрын батлагдсан орон тоо 29 бөгөөд одоо ажиллаж байгаа 28 албан хаагчаас ээлжийн амралттай 3, хүүхэд асрах чөлөөтэй 1 албан хаагч байгаа ба ёс зүйн хариуцлагын талонд арга хэмжээ авахуулсан албан хаагч байхгүй болно.

Төрийн албаны зөвлөлийн цахим програмд 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдөр тус газрын нийт албан хаагчдын энэ оны есдүгээр сард авсан нэмэгдлийн талаарх мэдээллийг оруулсан болно. Виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн ажлаас чөлөөлсөнтэй холбогдуулан тухайн албан хаагчийн ажлыг 2019 оны 10 дугаар сарын 11-ний өдөр хүлээлцүүлж акт үйлдсэн.

Тус газрын албан хаагчид төв болон тус газраас зохион байгуулсан дараах сургалтуудад хамрагдав. Үүнд:


- Төвөөс 2019 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр хүний нөөц, багаар ажиллах чадварын талаар зохион байгуулсан сургалтад тус газрын 7 албан хаагч, мөн 10 дугаар сарын 18-ны өдөр терроризмтой тэмцэх талаар зохион байгуулсан сургалтад тус газрын 11 албан хаагч хамрагдсан.

- Тус газраас 2019 оны 10 дугаар сарын 22-ны өдөр “Хувь хүний хөгжил ба манлайлал” сэдэвт сургалт зохион байгуулж “Саникон” ХХК-ийн зөвлөх багш мэдээлэл хийв. Тус сургалтанд 14 албан хаагч хамрагдсан бөгөөд өөрийгөө хэрхэн хөгжүүлэх, хөшүүргийн хүч, хөгжлийн процесс, хандлага болон амжилтын түлхүүр, манлайлал менежмент хоёрын ялгаа зэргийн талаарх мэдлэг олж авлаа.





- Тус газраас 2019 оны 10 дугаар сарын 22-ны өдөр “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргахад анхаарах зарим асуудлууд” сэдвийн хүрээнд зохион байгуулсан сургалтад ЭЗГХХ-ийн хуулийн ахлах мэргэжилтэн 14 албан хаагчдад мэдээлэл хийлээ.



2.4. Санхүү, хангалт үйлчилгээний ажлын талаар:

Тайлант хугацаанд батлагдсан төсвийг зохих зардлын дагуу зарцуулан өр, авлагагүй ажилласан ба холбогдох мэдээллийг шилэн дансанд байршуулсан.

Батлагдсан төсөв болох өссөн дүнгээр 505,395,200 төгрөгийн санхүүжилт орсноор цалин хөлсөнд 292,312,525 төгрөг, ажил олгогч болон даатгуулагчаас нийгмийн даатгалын шимтгэл 35,530,981 төгрөг, Хан-Уул дүүрэгт цалин хөлснөөс

суутгасан ашгийн татварт 14,499,253 төгрөг зарцуулж өглөг авлага үүсгээгүй ажиллалаа.

Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг гарган 2019.10.05-ны өдрийн дотор Нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлэн өссөн дүнгээр 53,025,981 төгрөгөөр тооцоо нийлэв. Төсвийн гүйцэтгэлийн мэдээг 2019.10.02-ны өдрийн дотор гарган Хан-Уул дүүргийн төрийн сангаар баталгаажуулан Санхүү, хангалт, үйлчилгээний газарт хүргүүлсэн. Мэдээгээр 454,284,600 төгрөгийн урсгал санхүүжилт орсоноос нийт зарлага 375,053,794 төгрөгийн ажил үйлчилгээ явуулсан.

Албан хаагчдад энэ сард шийтгэлийн хуудас 50, визийн хуудас 750 ширхэгийг шаардах хуудасны дагуу олгосон. Хүү торгууль өссөн дүнгээр 81,770,000 төгрөгийг Төв аймгийн төрийн санд, визийн тэмдэгтийн хураамж өссөн дүнгээр 512,969,100 төгрөгөөр тайлан нэгтгэн хяналтын улсын байцаагч нартай тооцоо нийлэн Гадаадын иргэн, харьяатын газрын Санхүү, хангалт, үйлчилгээний газарт хүргүүлсэн.

Албан хэрэгцээнд ашиглаж байгаа суурин утас болон интернетийн төлбөрт өссөн дүнгээр 2,138,147 төгрөг, байрны түрээс 30,307,500 төгрөг харилцагч байгууллагын нэхэмжлэхийн дагуу холбогдох данс уруу шилжүүлсэн болно.

Бараа материалд өссөн дүнгээр 11,883,197 төгрөгийн худалдан авалтыг хийж шаардах хуудасны дагуу албан хаагчдад өгсөн байна. Бараа материалын болон шатахууны тайланг гаргахдаа Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу анхан шатны баримтыг бүрдүүлэн гаргасан ба хянуулж баталгаажуулсан. Түлш шатах тослох материалд өссөн дүнгээр 10,905,700 төгрөгийн зарцуулалт гаргаж тайлагнасан байна.

Тус газрын 28 албан хаагч, хүүхэд асрах чөлөөтэй 1 албан хаагчийн нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын дэвтэрт холбогдох бичилтийг хийж Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээр баталгаажуулав.

Үйлчилгээнд явж буй Приус-20, Соната-7 автомашины цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийн хэвийн ажиллагааг ханган ажиллаж, батлагдсан маршрутын дагуу албан хаагчдыг тээвэрлэж, замын хуудсыг бөглөн санхүүтэй тооцоо нийлж ажиллав. Үйлчилгээнд явж буй 2 тээврийн хэрэгсэлд өссөн дүнгээр 1,515,180 /тухайн сард 640,000 төгрөгийн урсгал засварыг Соната-7 тээврийн хэрэгсэлд/ төгрөгийн урсгал засварын ажил хийж гүйцэтгэсэн байна.

2.5. Мэдээллийн технологийн чиглэлээр:

Тайлант хугацаанд нийт 20 удаа дуудлага хүлээн авч засварлан хэвийн ажиллагаанд оруулсан ба 1 зөөврийн компьютер, 2 суурин компьютерийг форматлан хэвийн ажиллагааг ханган ажилласан ба ил гарсан сүлжээний утас далдлах ажлыг хийсэн.

Олон улсын агаарын замын боомт дахь ирэгчийн өрөөний веб камерын тохиргоог хийж, үзэгдэх орчинг сайжруулах үүднээс хананд тогтоох ажлыг хийж гүйцэтгэв. “Чингис хаан” олон улсын нисэх буудлын Мэдээлэл технологийн газраас тус өрөөнд интернет сүлжээ татаж интернет сүлжээ орууллаа.

Төв газраас 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулсан онлайн хурлын холбогдох бэлтгэл ажлыг ханган холбогдож ажилласан.

Гурав. Олон нийттэй харилцах чиглэлээр

Тус газрын мэдээллийн самбар болон байгууллагын цахим хуудсанд 2019 оны 9 дүгээр сард хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, тайлан, зохион байгуулсан сургалт, өргөдөл, гомдлын мэдээ, 10 дугаар сард хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөг байршуулж олон нийтийг мэдээллээр хангаж ажиллалаа.

Байгууллагын орон нутагт хэрэгжүүлж буй чиг үүрэг, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор видео танилцуулга, тус газрын харьяалах аймаг, хилийн боомтын талаарх видео дүрс бичлэгийг бэлтгэн Захиргаа удирдлагын газарт 2019 оны 10 дугаар сарын 07-ны өдөр хүргүүлсэн.

Дөрөв. Байгууллагын даргын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан арга хэмжээний талаар

Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудалд 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдөр барилга байгууламжид гарсан гал түймэр, аюултай материалын осолтой холбоотой онцгой байдал “Код-F” төрлөөр хамтран ажиллагч байгууллагуудтай ширээний дасгал сургуулилтыг хийхэд тус газрын виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн оролцсон. Түүнчлэн шинэ нисэх буудалд байрлах өрөөний талаарх саналаа 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдөр 10/106 дугаар албан бичгээр “Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт” ХХК-д хүргүүлсэн.

Тав. Бусад

Байгууллагын даргын 2019 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 01-03/19 дугаар “АЗБХГ-ын албан хаагчдад давтан сургалт зохион байгуулах тухай” удирдамжийн дагуу тус газрын албан хаагчид мэргэшлийн мэдлэгийн түвшин тогтоох шалгалтыг мөн сарын 30-ны өдөр төв газарт өгсөн бөгөөд батлагдсан хувиарийн дагуу эхний ээлжинд 4 албан хаагч сургалтанд хамрагдлаа.

Тус газрын ээжит цугларалтыг 2019 оны 10 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулж албанд гарч буй хүндрэлийн талаар хэлэлцэж газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч үүрэг, чиглэл өгч ажиллалаа.

Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж сурталчлах, танин мэдүүлэх зорилгоор Буянт-Ухаа боомтод ажиллаж буй албан хаагчид биечлэн 314, утсаар 325 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгсөн байна.